



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/293

Булган сум


“Зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх үйл ажиллагаа”-ны 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахад дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.7 дэх хэсэг, мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн хэмжээнд “Зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх үйл ажиллагаа”-ны 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахад шаардагдах 10,000,000 (арван сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

2. Зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, үр дүнг салбар Зөвлөлд тайлагнаж ажиллахыг Тагнуулын Ерөнхий Газрын Булган аймаг дахь хэлтсийн дарга (хурандаа Б.Жавхлантагс)-д зөвлөсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ